



МОНГОЛ УЛСЫН  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот


Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6 дахь заалт болон Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 208 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 2023/06 дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу энэ тушаалын нэгдүгээр хавсралтад заасан 4 /дөрөв/ хуулийн этгээдэд геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээр олгосугай.

2. Энэ тушаалын хоёрдугаар хавсралтад заасан 11 /арван нэг/ хуулийн этгээдийн геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгасугай.

3. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, сунгасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батсайхан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газар /даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Батболд/-т тус тус даалгасугай.



Ц.ДАВААСҮРЭН

152301558